

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.НАРАНДУЛАМЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Эхний хагас жил	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
	1	2	3	4	5	6	7	
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Байгууллагын захиргаа, хүний нөөц, төсөв санхүүтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах (Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх)								
Зорилт 1.Байгууллагын захиргаа, хүний нөөцийн эрхэлсэн асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилт								
1	Арга хэмжээ: 3.1.6 Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, Хариуцлагын гэрээ, төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагад тайлагнах, нэгж, албан хаагчдын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагчдын	3.1.6.1. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг тайлагнах, хяналт тавих	-Хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийг тайлагнасан байх -Тайланг албан бичгээр хүргүүлсэн байх Хэрэгжилтийг холбогдох газарт тайлагнасан байдал	-Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. -Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг НЗДТГ-т 2023 оны 1/458, 1/699, 1/1203, 1/1583 дугаар албан бичгүүдээр тус тус тайлагнасан.	-Төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт, шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлэн ажилласан байна. -Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. -Төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнасан байна.	-Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдан, 58 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. -Төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журмын дагуу хагас, бүтэн жилийн тайлагнана. -Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 36 заалт бүхий төслийг боловсруулж, газрын даргаар батлуулсан.	01-05	100
2		3.1.6.2. Хариуцлагын гэрээ, түүний биелэлтийг дээд шатны				-2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга хариуцлагын гэрээ байгуулсан.	01-05	100

	хөдөлмөрийн гэрээг хугацаанд нь баталгаажуулах, тайлагнах	байгууллагад тайлагнах				Гэрээнд тусгагдсан 21 заалтын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан хариуцлагын гэрээний 21 заалтын хэрэгжилийг хагас, бүтэн жилээр тайлагнана.		
3	Арга хэмжээ: 3.1.10 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих		-Тарьсан модны тоо Цэнэг усалгаа хийсэн байдал	2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрүүдэд Налайх дүүргийн “Шинэ-Налайх” цэцэрлэгт хүрээлэнд 5 шинэс модны суулгасан.	1 мод тарих арга хэмжээ	2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн Өмчийн харилцааны газрын албан хаагчид Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 100 ширхэг хайлаас модыг зааврын дагуу тарьж, усалгаа, арчилгааг хийсэн.	05	100
4	Арга хэмжээ: 3.1.11 2024 оны “Тохижилт бүтээн байгуулалт”-ын жил төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу байгууллагын хэмжээнд арга хэмжээ шинээр санаачлан ажиллах		Төлөвлөгөөний хэрэгжилт	-	Холбогдох арга хэмжээнд оролцсон байна.	“Тохижилт бүтээн байгуулалт”-ын жилийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: -“Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээнд тус газрын албан хаагчид Сити товер барилгын Ашиглалтын захиргаатай хамтран 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байгууллагын гадна /Сити товер/ орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдлыг түүж, гадна шат, үүдний хэсэгт хөөстэй угаалга цэвэрлэгээ хийсэн. -Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 38 албан хаагч “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан хуваарийн дагуу	04-05	100

					Чингэлтэй дүүрэгт Баянбүрдийн тойргоос урагшаа Тусгаар тогтнолын талбайн урд үзүүр хүртэлх талбайн явган хүний замын дэргэдэх түүвэр хог хаягдлыг цэвэрлэсэн. -Иргэдийн эрүүл цэвэр орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хоггүй цэвэр орчинг бүрдүүлэхэд аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг дагуу 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо, Их наяд төвийн баруун талаас голын урд хэсгээрээ Энхтайваны гүүр хүртэлх орчны хог хаягдлыг цэвэрлэх ажилд нийт албан хаагчид оролцсон.		
Зорилт 4. Байгууллагын гаргасан бодлогын баримт бичиг, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зорилт							
5	Арга хэмжээ: 3.4.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэж тайлагнахад хяналт тавьж ажиллах	-Холбогдох газарт хүргүүлсэн эсэх	-Бодлогын баримт бичигт тусгасан байгууллагад хамаарах 4 заалтын хэрэгжилтийг улирал бүр нэгтгэн гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажилласан. -Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг сар	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан үнэлгээний журмын дагуу тайлагнасан байна.	Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 4 заалтын хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тайлагнан ажиллаж байна. 2024 оны 1, 2-р улиралд нэгтгэн НЗДТГ-т тайлагнахад хяналт тавьж ажиллалаа.	01-05	100

			бүр нэгтгэж, холбогдох газарт хүргүүлж ажилласан.				
6	Арга хэмжээ: 3.4.2 Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн мөрөөр ажил сайжруулах болон зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, ажил сайжруулах, үр дүнг тооцож ажиллах	-Ажил сайжруулах болон зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан байх Ирсэн зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулсан байх	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 3 хяналт шалгалт ажлын зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажилласан.	-Зөвлөмжийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажилласан байна. -Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг НЗДТГ, холбогдох хяналтын байгууллагуудад тайлагнасан байна.	-НЗДТГ-ын 2024.04.04-ний өдрийн 03/1773 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай” А/349 дугаар захирамжийг ирүүлсэн. Зөвлөмж ирүүлээгүй байна.	01-05	100
7	Арга хэмжээ 3.4.5 НӨХГ-ын даргын албан даалгавар, тушаал (үйл ажиллагааны чиглэлээр байгуулсан ажлын хэсэг)-ын хэрэгжилтэд хяналт тавих	-Хэрэгжилтийн хувь	100	100	-Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын А тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны 1 дүгээр улирлаар нийт 9 ажлын хэсгийн тушаал буюу А/05,08,09,10,13,34,36,37,38 дугаар тушаалын хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, ӨХАДАХ-т хүргүүлсэн. -Тайлант хугацаанд НӨХГ-ын албан даалгавар гараагүй болно.	01-05	100
8	Арга хэмжээ 3.4.6 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой газрын даргын баталсан нийт төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	-Төлөвлөгөөний хэрэгжилт	-	Хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 58 заалт, Хариуцлагын гэрээний 21 заалт, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 36 заалт, Байгууллагын 2024 оны	01-05	100

					нийтийн мэдээллийн ил тод байдлын төлөвлөгөөний 71 заалтын хэрэгжилтэд тус тус хяналт тавин ажиллаж байна.		
--	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах	Хэрэгжилтийн хуль	-	100	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллүүд бүхий байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг 1 дүгээр улирлын байдлаар гаргасан. Төлөвлөгөөнд тусгагдсан 71 заалт бүрийг байгууллагын цахим хуудастай тулган, холбоос линкийг оруулж тайлагнасан. 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 71 заалтын 10 заалт хэрэгжээгүй, 29 заалт хамааралгүй, 14 заалтад хамаарах мэдээллийг шинэчлэх шаардлагатай байна. Мөн байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/news -д 3 мэдээ, мэдээллийг байршуулж ажилласан.	03-05	100
2	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийх	Хэрэгжилтийн хуль	-	100	-Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах асуудлаар Улсын 1 дүгээр төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв эмнэлгүүдийн холбогдох ажилтантай холбогдон багц үзлэг шинжилгээний мэдээлэл, үнийн санал, боломжит хугацаа зэргийг авч харьцуулсан үнийн судалгаа, төсөв гаргаж, газрын даргад 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр танилцуулсан. - Дөл булга ХХК-ны Дөл дент шүдний эмнэлгийн хамт олон нийгмийн хариуцлагын	03-05	100

					хүрээнд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын нийт албан хаагч нарт "Амны хөндийн эрүүл мэнд"-ийн талаар сургалт, урьдчилан сэргийлэх үзлэг хийх хүсэлтийг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 59 дугаар албан бичгээр ирүүлсэн. Тус хүсэлтийн дагуу Дөл дент шүдний эмнэлгийн хамт олон 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 14 цагт Нийслэлийн Өмчийн харилцааны газар ирж "Амны хөндийн эрүүл мэнд"-ийн талаар сургалт зохион байгуулж, байгууллагын 15 албан хаагчдыг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. -2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ажлын байрны судалгаа буюу ажлын байрны нэг хүнд ногдох талбайн хэмжээ, засвар үйлчилгээ хийх шаардлагатай талбайн мэдээлэл зэргийг нэгтгэн газрын даргад танилцуулсан.		
3	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллах	Ажлын хэсээгт ажилласан эсэх (Тийм-1, Үгүй-0)	-	1	Нийслэлийн өмчит байгууллагуудын данснаас хасах тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааны анхны үнэ болон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах үнэ тогтоох тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээ хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг юм. Ажлын хэсгийн хурал 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 1620 минутад тус газрын 301 тоот өрөөнд эхэлж, НӨХГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/38 дугаар тушаалаар батлагдсан комиссын бүрэлдэхүүн 100 хувийн ирцтэйгээр оролцсон. Тус хурлын тэмдэглэлийг албажуулж, холбогдох шийдвэрийг гаргасан. Энэ асуудалтай холбогдуулан сонгон шалгаруулалтын зарын дагуу 1 байгууллагаас буюу "Файн эстимэйт" ХХК-аас материал ирүүлж, ирсэн материалыг ажлын хэсэг хянан шалгаж үзэхэд манай байгууллагаас тавьсан шаардлагыг хангаж, үүнийг дагуу тухайн байгууллагыг комиссын гишүүдийн саналаар баталгаажуулж, тухайн	03	100

					байгууллагатай хэлэлцээр хийхийг Ажлын хэсэгт даалгасан. 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр “Файн эстимэйт” ХХК-тай хэлэлцээр хийж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.		
4	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/37 дугаар тушаалаар ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллах	Ажлын хэсэгт ажилласан эсэх (Тийм-1, Үгүй-0)	-	1	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанд танилцуулагдсан “Нийслэлийн өмчид барилга байгууламж бүртгэн авах тухай” НӨХГ-ын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 2/467 дугаар албан бичгээр НИТХ-ын Ажлын албанд хүргүүлсэн асуудалд арифметик алдаа байсан эсэхийг тогтоох ажлын хэсэг юм. Ажлын хэсгийн хурал 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 09 ²⁰ минутад тус газрын Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн даргын өрөөнд болж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн 80 хувийн ирцтэйгээр оролцсон. Ажлын хэсгийн гишүүн Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хуулийн мэргэжилтэн С.Учрал шүүх хуралдаанд оролцож байгаа шалтгаанаар биечлэн хуралд оролцоогүй ч саналаа тусгааа илэрхийсэн. Хурлын тэмдэглэлийг албажуулж, холбогдох шийдвэрийг гаргасан. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 4/500 дугаар албан бичгийг хурлын тэмдэглэлийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажиллалаа.	03	100
5	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/77 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллах	Ажлын хэсэгт ажилласан эсэх (Тийм-1, Үгүй-0)	-	1	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/77 дугаар тушаалаар томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нь Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр баталсан 01 дугаар “Хишиг-Уул” ХК-ийн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд шалгалт хийх ажлын удирдамжын дагуу 2024 оны 04 дүгээр 25-26-ны өдрүүдэд Нийслэлийн Багануур дүүрэгт байрлах “Хишиг-	04-05	100

					Уул" ХК-ны одоогийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж ажиллалаа.Хийсэн хяналт шалгалтын хүрээнд хяналт шалгалтын тайлан, танилцуулга (РРТ)-ыг тус тус нэгтгэн, ажлын хэсгийн даргад хүргүүлсэн. Тайланг гарын үсгээр баталгаажуулж ажлын хэсгийн даргад өгсөн.		
6	Байгууллагын ёс зүйн дэд хороонд гишүүнээр ажиллах	Хэрэгжилтийн хувь	-	100	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн "Ёс зүйн дэд хороо шинэчлэн байгуулах тухай" А/76 дугаар тушаалын дагуу Ёс зүйн дэд хороонд гишүүнээр ажиллалаа. Тус хугацаанд дэд хороонд 1 өргөдөл, гомдол ирж, тус өргөдөл гомдлыг хянан шалгаж, холбогдох албан хаагчдаас тайлбар, мдэлээллийг авч, дэд хорооноос дүгнэлт гарган шийдвэрлэсэн. Мөн холбогдох хууль, журмын дагуу байгууллагын ёс зүйн дэд хорооны "Хурлын дэг"-ийн төслийг боловсруулан, гишүүдээс санал авч ажилласан.	04-05	100
7	НЗДТГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/92 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллах	Ажлын хэсэгт ажилласан эсэх (Тийм-1, Үгүй-0)	-	1	НЗДТГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/92 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 01 дүгээр хурлын бэлтгэл ажлыг хангаж, хурлын хөтөлбөрийг боловсруулан Ажлын хэсгийн дарга НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбадрахаар батлуулсан. Хуралд танилцуулах материалыг гишүүдэд хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр ажлын хэсэг хуралдсан. Хурлын тэмдэглэлийг хөтлөж ажилласан. 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ажлын хэсгийн холбогдох гишүүд газар дээр нь очиж хөрөнгийг үзэх, фото зургаар баримтжуулах ажил хийгдэнэ. Ажлын хэсгийн ажил үргэлжилж байна.	05	100
8	Хөрөнгө, аж ахуйтай холбоотой хийх ажлууд	Хэрэгжилтийн хувь	-	100	-2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 3587 тээврийн хэрэгслийг тулган, улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр сольсон тухай судалгааг нэгтгэн ӨХАДАХ-т хүргүүлсэн.	03-04	100

					-2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр аж ахуйн хашаанд байршуулах камерийн үнийн судалгааг гаргаж, газрын даргад танилцуулсан.		
9	Дээд газраас зохион байгуулсан Аянуудыг хэмжээнд байгууллагын зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь	-	100	1.2024 оны 03 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан зохион байгуулж буй үндэсний хэмжээний “Харилцан хүндэтгэе” аяныг зохион байгуулсан. Үүнд: -Төрийн албан хаагчдыг албан харилцаандаа жендэрийн мэдрэмжтэй хандаж, сайжруулахад нь туслах зорилго бүхий MERIT төслөөс боловсруулсан “Жендэрийн мэдрэмжтэй харилцаа холбоо” цахим сургалт (https://training-mongolia.thinkific.com/courses/communication) –д тус байгууллагын 12 албан хаагчид цахимаар хамрагдсан. - Тус аянд 2 төрлийн постер бэлтгэж, ERP системийн үйл явдал цэс, байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудсанд тус тус байршуулж ажилласан. Зурагт хуудсуудыг олон нийтэд сурталчилах зорилгоор байгууллагын ханын самбаруудад байршуулж, байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудсанд тус тус байршуулсан. 2.Шар усны үерээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Нэг хот-нэг гэр бүл” уриан дор зохион байгуулсан аянд нэгдэж, МУГЖ Б.Жаргалсайхантай хамтран уриалга видео бэлтгэн, байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээсэн.	02-05	100
10	Түрээсийн үнийн судалгаа хийх	Хэрэгжилтийн хувь	-	100	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын дагуу нийслэлийн	02	100

					өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод, жишиг үнийг шинэчлэн боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах бэлтгэл ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороонд "дэмжлэг хүсэх тухай" 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/271 дугаар албан бичиг хүргүүлсэн. Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын компаниудын 2023 онд үл хөдлөх хөрөнгийг хөлслөх, хөлслүүлэх, түрээслэх, түрээслүүлэх үйл ажиллагааг зуучилсан мэдээнд үндэслэн арилжааны зориулалттай үл хөдлөх хөрөнгө болон орон сууцны түрээсийн үнийн судалгааг тус газарт ирүүлсэн. Ирсэн задгай судалгааг нэгтгэн, илтгэх хуудсаар 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр газрын даргад танилцуулсан.		
11	Ирсэн албан бичгийг судалж, шийдвэрлэх	Хэрэгжилтийн хувь	-	100	Тайлант хугацаанд нийт дээд газраас болон буад холбогдох байгууллагуудаас ирсэн 31 албан бичгийг судалж, заасан хугацаанд нь хариу хүргүүлж ажиллалаа. Мөн 18 албан бичгийг гадагш хүргүүлсэн.	02-05	100

Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн хэрэглээний болон салбарын хууль тогтоомжид заасан	Холбогдох газраас зохион байгуулсан сургалтуудад	Холбогдох газруудаас зохион байгуулсан 8	4	Тайлант хугацаанд нийт 4 сургалтад хамрагдсан. Үүнд:	01-05	100

	зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмших	хамрагдсан тоо	сургалтад хамрагдсан.		-2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр "Төрийн албан хаагчийн манлайлал" сэдэвт сургалт -2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр "Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050" сэдэвт сургалт -2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр "MS Excel /дунд шат, ахисан шат/" сэдэвт сургалт -2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх" сэдэвт сургалтуудад тус тус хамрагдсан.		
2	Арга хэмжээ 2. Боловсролын зэргээ ахиулахаар магистрын сургалтад суралцах	Магистрын сургалтад хамрагдсан байдал (Тийм-1, Үгүй-0)	-	1	Удирдлагын Академийн "Төрийн захиргааны менежмент"-ийн магистрын сургалтад элсэн орж, тайлант хугацаанд судалвал зохих хичээлүүдийг судалж дуусгасан. Дипломын судалгааны ажил хийгдэж байна.	01-05	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах, төлөвлөлт хариуцсан
мэргэжилтэн

(Албан тушаал)



М. Нарандулам
(Нэр, гарын үсэг)

2024.05.20.

(Огноо)